

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

1. “Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/ 3-4

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
03 дугаар сарын 27-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 29 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Бат-Амгалан, Д.Бат-Эрдэнэ, Ж.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Б.Дэлгэрсайхан, Д.Цогтбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, С.Одонтуяа.

Нэг. “Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, Хамтын ажиллагааны төв” ТӨҮГ-ын захирал Ж.Чойханд, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, Даян дэлхийн ногоон хөгжлийн институтын ахлах мэргэжилтэн Э.Баярмаа, Ч.Баярхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5-д заасны дагуу танилцуулга хийх Засгийн газрын гишүүн байхгүй байгааг мэдэгдэж, “Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээр”-ийн төслийн зөвшилцөх асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулав./14:35/

Хуралдаан 06 минут үргэлжилж, 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 29 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Хүмүүсээ оруулаарай.

Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийн мэдээллийг та бүхэнд танилцуулъя.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг ирсэн, Ганибалын Амартүвшин ирсэн, Пүрэв-Очирын Анужсин ирсэн, Хавдисламын Баделхан ирсэн, Энхтайваны Бат-Амгалан орон нутагт томилолттой, Баагаагийн Баттөмөр ирсэн, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ орон нутагт томилолттой, Сүхбаатарын Батболд өвчтэй, Дашдондогийн Ганбат ирсэн, Борхүүгийн Дэлгэрсайхан чөлөөтэй, Нанзадын Наранбаатар ирсэн, Салдангийн Одонтуяа өвчтэй, Цэдэвийн Сэргэлэн ирсэн, Дамдины Цогтбаатар ирсэн. Цогтбаатар гишүүнд хэлээрэй. Одоо орж ирнэ гэсэн тээ? Нямаагийн Энхболд ирсэн. Гишүүдийн ирц хүрсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны энэ өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдаанаар “Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцэнэ.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын Засгийн газрын гишүүн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ байна уу? Бат-Эрдэнэ сайд хааччихсан юм? Засгийн хуралдаанаасаа? Байгаль орчны яамнаас тэгээд хэн байгаа юм? Мягмаржавын Ганбаатар Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд байхгүй байна уу? Байхгүй байна. Даваадоржийн Санчир Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга байна уу? Алга байна. Жанчивламдангийн Чойханд Уур амьсгалтын өөрчлөлтийн судалгаа, Хамтын ажиллагааны төв ТӨҮГ-ын захирал байна уу? Алга байна. Гадаад харилцааны яам Сүхээгийн Сүхболд Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал. Танай Төрийн нарийн хааччихсан юм? Төрийн нарийн чинь оролцох ёстой шүү дээ энд. Даян дэлхийн ногоон хөгжлийн институт Э.Баярмаа ахлах мэргэжилтэн, Ч.Баярхүү ахлах мэргэжилтэн.

Энэ асуудлаа оруулах хүмүүс чинь хааччихсан юм бэ? Нэг нь ч байхгүй. Энэ яагаад байгаа юм? Их Хуралд жоохон хүндэтгэлгүй хандаад байгаа юм уу? Энэ хурал чинь хоёр дахь, гурав дахиа хойшилж байна шүү дээ. Энэ асуудал Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 22 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн мягмар гаргийн хуралдаанаар орж ирсэн. Танай сайд бас байгаагүй. Тэгээд тэрний дараа наадах чинь бид нар энэ асуудлыг Төсвийн байнгын хороогоор хуралдуулж санал, дүгнэлт авч байж орж ирэх ёстой гээд тэгээд хойшлогдсон.

Төсвийн байнгын хороогоор орсон ч юм байхгүй дахиад ороод ирж байгаа.

Тэгээд оруулж ирэх ёстой Засгийн газрын сайд нь ч байдаггүй, хүмүүс нь байдаггүй. Одоо яах ёстой юм? Байгаль орчны яам хэн бэ өөрөө? Жанчивламдангийн Чойханд мөн үү? Тэгээд Байгаль орчных нь сайд нь ч байдаггүй, дэд сайд нь ч байдаггүй, оруулж байгаа хүмүүс нь ч байхгүй.

Засгийн газраас санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.2-т зааснаар Засгийн газраас санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг Ерөнхий сайд, эсвэл тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эсвэл тухайн Засгийн газрын гишүүнийг түр эзгүй байхад түүнийг орлож байгаа Засгийн газрын гишүүн хийнэ гэж байгаа юм. Засгийн газрын гишүүд нь алга байна, нэг. Энэ бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.2-оор.

Хоёрдугаарт, нөхдүүд ээ энэ оруулж ирж байгаа юмаа хараарай. Та нар бол одоо буцаагаад, үүнийгээ янзлаад оруулаад ирье гэж яриад гол нь явсан санагдах юм.

Олон улсын байгууллагын ойлголт, дипломат эрх зүйн тухай ойлголт, дипломат дархан эрх зүй, эрх ямбаны тухай ойлголт, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын тухай ойлголт, Засгийн газрын бус олон улсын байгууллагын тухай ойлголтуудаа та нар чинь холиод байгаа юм биш үү? Гадаад харилцааны яам энэ дээр анхаараарай. Та нар ямар хүмүүст дипломат эрх ямба олгодог юм, ямар хүмүүст олон улсын байгууллагын эрх ямба олгодог юм бэ гэдгийгээ. Үүнийгээ дараагийн удаад үүнийгээ сайн харж, ярьж оруулж ирээрэй.

Венийн конвенцоор наад олон улсын байгууллага чинь бол ямар ч буруугүй л юм байна лээ шүү дээ. Наадуул чинь ажлаа хийх гээд л, юмаа явуулах гээд л байдаг.

Та нар юмаа буруу оруулж ирчхээд, тэгээд оруулж ирсэн буруу юмаа болохоор зэрэг энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр гацчихлаа гэж энд, тэнд битгий яриад байгаарай та нар. Тийм юм байхгүй шүү.

Олон улсын дипломат эрх ямбыг бол зөвхөн Венийн конвенцын нэгдэн орсон Венийн конвенцын дагуу олгодог.

Олон улсын байгууллагын эрх ямбыг өөр статусаар олгодог. Тэр хоёрыгоо ялгахгүй оруулж ирчхээд тэгээд энэ дээр, манай дээр гацчихсан юм шиг юм яриад байдаг. Тэгээд сайд нь ч байдаггүй.

Энэ асуудал дараагийн долоо хоног болтол хойшлогдлоо.

Наадхаа та нар нэлээн сайн харж байж оруулж ирээрэй. Хурал хойшлогдлоо.

14.35 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР